



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2024 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 15

Мандалговь

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл  
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 798 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 4 дүгээр зүйлийн 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Адаацаг суманд барьж, ашиглалтад оруулсан нийт 1,955,145,705 (нэг тэрбум есөн зуун тавин таван сая нэг зуун дөчин таван мянга долоон зуун тав) төгрөгийн өртөгтэй спорт заалны барилгыг Адаацаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн хөрөнгөд хавсралтын дагуу бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Адаацаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал (Б.Даваажаргал)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2024 оны 5 дугаар сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.ОДЭРДЭНЭ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2024 оны 04 дүгээр сарын 22-ний өдрийн  
тогтоолын хавсралт

Адаацаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн хөрөнгөд  
бүртгэх хөрөнгийн мэдээлэл

№	Хөрөнгийн нэр	Биет хэмжээ	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Спорт заалны барилга	м.кв	657.22		1,560,720,675
2	Гадна дулаан	м	75	3,164,454	237,334,050
3	Гадна ус хангамж	м	95	358,104	34,019,880
4	Гадна бохир	м	21	301,370	6,328,770
5	Гадна цахилгаан	м	225	43,045	9,685,125
6	Гадна холбоо	м	240	17,007	4,081,680
7	Бохир усны цооног	м.куб	40	865,065	34,602,600
8	Гадна тохижилт				
	- Мод	ш	90	61,734	5,556,060
	- Гэрэлтүүлэг	ш	6	459,894	2,759,364
	- Сандал	ш	6	214,996	1,289,976
	- Хогийн сав	ш	2	157,095	314,190
9	Авто машины зогсоол	м.кв	360	118,973	42,830,280
10	Явган хүний зам	м.кв	315	49,597	15,623,055
<b>Нийт төсөвт өртөг</b>					<b>1,955,145,705 (нэг тэрбум есөн зуун тавин таван сая нэг зуун дөчин таван мянга долоон зуун тав) төгрөг</b>